



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/99

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 55 дугаар зүйлийн 55.1.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-д доор дурдсан агуулгатай 3.10, 4.7, 4.8 дахь заалт нэмсүгэй:

“3.10.Өрсөлдөөний байгууллага хуулийн 58.3-т заасны дагуу өөр этгээдийн гомдлоор шийдвэрлэж хариу өгсөн асуудал бол гомдол гаргагчид хүргүүлэх албан бичигт өмнөх шийдвэрийн хуулбарыг хавсаргана.

4.7.Сангийн яам хуулийн 59.5-д заасны дагуу өөр этгээдийн гомдлоор шийдвэрлэж хариу өгсөн асуудал бол гомдол гаргагчид хүргүүлэх албан бичигт өмнөх шийдвэрийн хуулбарыг хавсаргана.

4.8.Захиалагч хуулийн 28.1-д заасан шийдвэрийг хуулийн 28.3-т зааснаар нийтэлснээс хойш тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг дахин хийж, ижил үндэслэлээр шийдвэрийг хэвээр үлдээсэн бол шийдвэрийг хэвээр үлдээсэн тухай оролцогчид мэдэгдэнэ. Ижил үндэслэл бүхий захиалагчийн шийдвэрт хуулийн 59.1-д заасан гомдол гаргах хугацааг эхний шийдвэрийг цахим системд нийтэлсэн өдрөөс тоолно.”

2.Журмын 3.5-ын “мэдээллийг” гэсний дараа “утсаар тухайн өдөрт багтаан мэдэгдэж,” гэж, 4.6 дахь заалтын “зөрчсөн” гэсний дараа “, эсхүл санхүүжилтийн эх үүсвэргүй болсон тендер шалгаруулалттай холбоотой” гэж тус тус нэмсүгэй.

3.Журмын 5.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.5.Сангийн яам хуулийн 48.4-т заасан тендер шалгаруулалтын хувийн хэргээс гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд холбоотой баримт бичгийг цахимаар, эсхүл бичгээр ирүүлэхийг захиалагчаас шаардана.”


4.Журмын 1.1, 3.1, 3.4, 3.5, 3.7, 3.8, 3.9 дэх заалтын “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар” гэснийг “өрсөлдөөний байгууллага” гэж, 2.2.4 дэх заалтын, 3 дугаар бүлгийн гарчгийн, 3.3 дахь заалтын “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт” гэснийг “өрсөлдөөний байгууллагад” гэж тус тус өөрчилсүгэй.

9763000246

5.Журмын 3.3 дахь заалтын “энэ журмын 2.7-д зааснаас гадна” гэснийг хассугай.

6.Журмын 5.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

7.Энэ тушаалын дагуу холбогдох өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Хууль, эрх зүйн газар (З.Энхболд)-т даалгасугай.

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains a central emblem with a flame and a yin-yang symbol, flanked by vertical text in Mongolian script. The signature is written in a cursive style.

Б.ЖАВХЛАН